



Засгийн газрын төвлөрлийг сааруулах бодлогын хэрэгжилтийн талаар

**Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Орон нутгийн удирдлага,
зохицуулалтын газрын дарга П.Зоригтбаатар**

АГУУЛГА

- “Төвлөрлийг сааруулах талаар төрөөс баримтлах бодлого”-ын талаар товч танилцуулга
- Чиг үүргийг хуваарилах аргачлалын тухай

ТӨВЛӨРЛИЙГ СААРУУЛАХ ТАЛААР ТӨРӨӨС БАРИМТЛАХ БОДЛОГО

ЗАСГИЙН ГАЗРЫН 2016 ОНЫ 350 ДУГААР ТОГТООЛ

Монгол Улс дахь төвлөрлийг сааруулах үйл явцыг дараах үе шатанд хуваан авч үзэж болно:

1. 1992-2002 он буюу төвлөрлийг сааруулах бодлогыг идэвхтэй дэмжиж, тодорхой үе шатны арга хэмжээг авч хэрэгжүүлсэн үе;
2. 2002-2012 он буюу эрх мэдлийг эргэн төвлөрүүлсэн, орон нутгийн бие даасан байдал бүтэц, зохион байгуулалт, санхүү, төсвийн хувьд суларсан үе;
3. 2012 оноос төсвийн төвлөрлийг сааруулах зорилгоор иргэдийн оролцоог нэмэгдүүлэх чиглэлээр шинэ арга хэмжээ хэрэгжүүлж эхэлсэн үе.

Төвлөрлийг сааруулах бодлого боловсруулах хэрэгцээ, шаардлага

- Яамдад эрх мэдэл хэт төвлөрсөн
- нутгийн өөрөө удирдах болон захиргааны байгууллагын хэрэгжүүлэх чиг үүрэг давхардсан,
- Орон нутагт йл ажиллагааг санхүүжүүлэх санхүүгийн нөөц дутагдалтай, улсын төсвөөс олгох санхүүгийн дэмжлэгээс ихээхэн хамааралтай
- төвөөс алслагдсан сум, багийн түвшинд иргэдэд хүргэх төрийн үйлчилгээний чанар, хүртээмж хангалтгүй
- анхан шатанд үйлчилгээ үзүүлэх үүрэг бүхий засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн хүний нөөц, түүний чадавх бэхжээгүй

ТӨВЛӨРЛИЙГ СААРУУЛАХ БОДЛОГЫН ҮНДСЭН ЗОРИЛГО, ЧИГЛЭЛ, ЗАРЧИМ:

ЗОРИЛГО

Монгол Улсад төвлөрлийг сааруулах үйл явцыг тодорхой үе шатаар харилцан уялдаатай, цогц байдлаар хэрэгжүүлэх замаар төрийн үйлчилгээний үр ашиг, чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх, шийдвэр гаргах түвшинд иргэдийн оролцоог хэлбэрэлтгүй хангах, нээлттэй, хариуцлагатай, сайн засаглалыг бүрдүүлэн эдийн засаг, нийгмийн хөгжлийг дэмжих нөхцөлийг бүрдүүлэхэд оршино.

Зарчим

-Субсидиар зарчим. Энэ нь чиг үүргийг иргэдэд хамгийн ойр хэрэгжүүлэх чадавхи бүхий анхан, дунд шатны нэгжид хуваарилахыг хэлн

-Чиг үүргийг тодорхой хуваарилах зарчим. Энэ нь холбогдох хуулиар чиг үүргийг түвшин хоорондын давхардалгүй, тодорхой хуваарилахыг хэлнэ.

-Чиг үүргийг санхүүжүүлэх зарчим. Энэ нь тухайн чиг үүргийг хэрэгжүүлэхэд шаардагдах санхүүгийн эх үүсвэрийн хамт хуваарилахыг хэлнэ.

-Чиг үүргийг хамтран хэрэгжүүлэх зарчим. Энэ нь шаардлагатай тохиолдолд төрийн үйлчилгээг үр дүнтэй, хүртээмжтэй хүргэх зорилгоор тухайн чиг үүргийг дээд болон доод шатны засаг захиргааны байгууллагууд босоо болон хэвтээ түвшинд хамтран хэрэгжүүлэхийг хэлнэ.

Төвлөрөл сааруулалтын хэлбэр

- Улс төрийн төвлөрөл сааруулах,
- Захиргааны төвлөрөл сааруулах,
- Төсвийн төвлөрөл сааруулах,
- Эдийн засгийн төвлөрлийг сааруулах,

БОДЛОГЫН ЗОРИЛТ, ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ЗАМ

- Нутгийн удирдлагын байгууллагын бодлого боловсруулах, шийдвэр гаргах үйл явцад иргэд болон иргэний нийгмийн байгууллагын оролцоог нэмэгдүүлэх замаар улс төрийн төвлөрлийг сааруулах;
- Төрийн байгууллагын бүтэц, зохион байгуулалт, тогтолцоог боловсронгуй болгох, чиг үүргийг дахин хуваарилах, хүний нөөцийн тогтвортой бодлогыг хангах замаар захиргааны төвлөрлийг сааруулах;
- Орон нутгийн эдийн засаг, санхүүгийн бие даасан байдлыг нэмэгдүүлэх замаар төсвийн төвлөрлийг сааруулах;
- төр, хувийн хэвшлийн түншлэлийг хөгжүүлэх, төрийн болон орон нутгийн байгууллагын зарим чиг үүргийг гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлэх, нийгмийн салбарын хувьчлалыг үргэлжлүүлэх замаар эдийн засгийн төвлөрлийг сааруулах.

Арга хэрэгсэл:

Чиг үүргийн дахин хуваарилалт:

-төрийн байгууллага, нутгийн удирдлагын болон захиргааны байгууллагын чиг үүргийг дахин хуваарилах аргачлал боловсруулж, тодорхой салбарт туршсаны үндсэн дээр холбогдох хууль тогтоомжид өөрчлөлт оруулан нийтлэг байдлаар хэрэгжүүлнэ;

Орлого, эх үүсвэрийн хуваарилалт:

-орон нутгийн түвшинд дахин хуваарилсан чиг үүргийг хэрэгжүүлэхэд шаардлагатай санхүүгийн эх үүсвэрийг холбогдох төсөвт тусгасны үндсэн дээр хуваарилна;

-орон нутгийн төсвийн орлогын төрлийг нэмэгдүүлэх асуудлыг судалж шийдвэрлүүлнэ.

Төсвийн тэнцвэржүүлэлт:

-орон нутагт хуваарилсан чиг үүргийг хэрэгжүүлэхэд шаардлагатай хөрөнгө болон орон нутгийн өөрийн орлого хоорондын зөрүүг төсвийн тэнцвэржүүлэлтийн аргаар шийдвэрлэх;

-санхүүгийн дэмжлэг болон төсөв хоорондын орлогын хуваарилалтын өнөөгийн тогтолцоог боловсронгуй болгох.

Нэгдсэн тэнцэл:

-төрийн байгууллага болон орон нутгийн удирдлагын байгууллагын чиг үүргийн дахин хуваарилалттай холбогдон үүсэх санхүүгийн үр дагаврыг нэгдсэн төсвийн хэмжээнд тооцох.

ЧИГ ҮҮРГИЙГ ХУВААРИЛАХ АРГАЧЛАЛ

Засгийн газрын 2018 оны 22 дугаар тогтоол

Чиг үүрэг гэдэг нь:

Чиг үүрэг гэдэг нь төрийн байгууллагад хуулиар тогтоосон эрх мэдлийн хүрээнд тодорхой үр дүнд хүрэх зорилгоор хэрэгжүүлж байгаа үйл ажиллагааны тогтвортой чиглэлийг хэлнэ.

**Чиг үүргийг дахин хуваарилах
аргачлалын хууль, эрх зүйн үндэслэл**

Төсвийн тухай хууль:

Яам, агентлаг, төсвийн бусад байгууллагуудад 3-5 жил тутамд нэг удаа чиг үүргийн иж бүрэн шинжилгээ хийж дүнг Засгийн газарт танилцуулна. Чиг үүргийн шинжилгээ хийх, дахин хуваарилах аргачлалыг Засгийн газар батлана.

Төвлөрлийг сааруулах талаар төрөөс баримтлах бодлогын баримт бичиг:
Чиг үүргийг дахин хуваарилах аргачлал боловсруулна, туршина батална.

Чиг үүргийг хэн
ТОГТООХ ВЭ?

Олон улсын гэрээ
конвенциор


Монгол улсын Үндсэн
болон бусад хуулиар

Хэн

Юу хийх вэ?

Төрийн болон нутгийн
удирдлагын
байгууллагууд

Өөрт ногдуулсан чиг
үүрэг, эрх хэмжээг
хэрэгжүүлнэ.



Чиг үүргийн шинжилгээ

1. төрийн байгууллагын чиг үүрэг хууль тогтоомж, эрх зүйн бусад актад хэрхэн тусгагдаж хуваарилагдсаныг тогтоох;


2. төрийн байгууллагын үндсэн болон дэд чиг үүргийг тодорхойлох;

Зорилго


3. Цаашид ТБ зайлшгүй хэрэгжүүлэх шаардлагатай, эсхүл холбогдох ТББ, хувийн хэвшил, мэргэжлийн холбоодоор гүйцэтгүүлэх боломжтой эсэхийг тодорхойлох

4. хууль тогтоомжоор тогтоосон чиг үүргийн хэрэгжилт болон давхардал хийдлийг илрүүлэн, үнэлэлт, дүгнэлт өгөх;


Чиг үүргийн ангилал




Чиг үүргийн дахин хуваарилалт



Монгол улсын хуулиуд



Удирдлага, зохион байгуулалт



Удирдлага, зохион байгуулалт

- Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт “Зөвлөлдөх ажлын хэсэг”
- Яамдад “Техникийн ажлын хэсэг”

ЗАХИРГААНЫ ЭРХ МЭДЛИЙН ХУВААРИЛАЛТ

Захиргааны эрх мэдэл	Яам агентлаг		Аймаг/ нийслэл		Сум/дүүрэг		Хувийн хэвшил	
	одоо	санал	одоо	санал	одоо	санал	одоо	санал
Бодлого боловсруулах /стандарт, стратеги төлөвлөлт								
Зохицуулалт хийх /салбар дундын түвшин хоорондын зохицуулалт /								
Зохион байгуулах /тухайн чиг үүргийн хэрэгжүүлэхтэй холбогдох зохион байгуулалт/								
Санхүүжилт /тухайн чиг үүргийн хэрэгжилтийг санхүүжүүлэх/								
Хүний нөөцийн бодлого /Боловсон хүчний томилгоо/								
Үйлчилгээ хүргэх /тухайн чиг үүргийг хэрэгжилтийг хариуцах/								
Хяналт /тухайн чиг үүргийн хэрэгжилтэд тавих хяналт								

АНХААРАЛ ТАВЬСАНД
БАЯРЛАЛАА